

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /1/НА-СТА-ТӨХК

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг:
narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Залруулсан алдаа.....	16
8.2 Төлбөрийн акт	16
8.3 Албан шаардлага.....	14
8.4 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.14 № 96
танай _____-ны № _____-т

ОРХОН АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц.БАТЗОРИГ
ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 620 дугаар тогтоолоор Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,337.5 сая төгрөгөөр баталсан. Харин Зам тээврийн сайдын 2021 оны 2 дугаар

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

сарын 26-ны өдрийн А/27 дугаар тушаалаар зам арчлалтын төлөвлөгөөг 1,048.99 сая төгрөгөөр баталсан нь хоорондоо 288.5 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Орхон АЗЗА ТӨХК-ийн орлогыг улсын чанартай авто замаас 1,121,034.0 мянган төгрөг, орон нутгийн чанартай авто замаас 216,500.0 мянган төгрөг, нийт 1,337,534.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр улсын чанартай авто замаас 978,103.5 мянган төгрөг буюу 87.25%-ийн гүйцэтгэлтэй, орон нутгийн чанартай авто замаас 222,216.8 мянган төгрөг буюу 102.6%-ын гүйцэтгэлтэй, нийт орлого 1,200,320.3 мянган төгрөг буюу 89.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,198,021.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 83,365.3 мянган төгрөг буюу 6.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь хөрөнгө оруулалтын зардлаас 15,000.0 мянган төгрөг, цалингийн сангаас 35,235.3 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал 9,621.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 2 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 9,472.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажилд 18,025.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийж үндсэн хөрөнгийг капиталжуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх

талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	342,721,293.48	388,890,304.99
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	89,115,211.71	48,299,935.27
1.1.2	Дансны авлага	186,798,149.32	168.686.061631
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	180,294.18	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	66,627,638.27	171,904,308.41
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	646,551,951.34	
1.2.1	Үндсэн хөрөнгө	362,232,841.32	643,501,251.55
1.2.2	Биет бус хөрөнгө	284,080,000.0	4,800,000
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	239,110.02	239,110.02
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	646,551,951.34	648,540,361.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	989,273,244.82	1,037,430,666.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	750,994,746.54	
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	124,100,790.54	
2.1.1.1	Дансны өглөг	10,454.67	10,454.67
2.1.1.2	Цалингийн өглөг	5,000.0	
2.1.1.3	Татварын өр	124,057,990.43	171,464,743.95
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	27,345.44	
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	626,893,956.0	171,475,198.61
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		

2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	626,893,956.0	626,893,956.0
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	626,893,956.0	626,893,956.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	750,994,746.54	798,369,154.61
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	629,227,688.87	629,227,688.87
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	255,903,164.14	255,903,164.14
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(646,852,354.73)	(646,069,341.06)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	238,278,498.28	239,061,511.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	989,273,244.82	1,037,430,666.56

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,206,393,070.0	1,166,936,126.37
2	Борлуулалтын өртөг	938,306,273.47	994,659,403.59
3	Нийт ашиг(алдагдал)	268,086,796.53	172,276,722.78
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	1,742,084.03	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	7,282,443.0	33,384,188.27
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	214,513,647.68	203,362,250.27
11	Санхүүгийн зардал	27,386,129.31	
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	35,211,546.57	2,298,660.78
19	Орлогын татварын зардал	3,521,154.66	229,866.08
20	Татварын дараах ашиг (алдагдал)	31,690,391.91	2,068,794.7
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	31,690,391.91	2,068,794.7
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(678,542,746.65)	206,588,106.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(678,542,746.65)	206,588,106.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					31,690,391.92	31,690,391.92
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(646,852,354.73)	238,278,498.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(1,285,781)	(1,285,781)
Залруулсан үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(648,138,135.73)	236,992,717.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					2,068,794.7	2,068,794.7
Зарласан ногдол ашиг						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	629,227,688.87		255,903,164.14		(646,069,341.06)	239,061,511.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,359,176,197.8	1,302,474,986.54
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,321,063,377.0	1,283,209,739.0
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,217,817.0	1,651,845.0
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	28,895,003.8	17,613,402.54
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,365,780,702.2	1,329,701,323.98
	Ажиллагчдад төлсөн	369,887,950.0	329,292,668.77
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	100,626,444.8	106,848,705.64
	Бараа материал худалдан авахад төлсөн	359,756,152.9	503,078,728.0
	Ашиглалтын зардалд төлсөн	28,320,596.8	14,811,502.04
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	258,495,547.9	301,541,256.0
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	211,849,128.3	35,188,297.3
	Даатгалын төлбөрт төлсөн	9,141,894.5	2,718,659.0
	Бусад мөнгөн зарлага	27,702,987.0	36,211,507.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,604,504.4)	(27,226,337.44)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	1,742,084.03	
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,999,900.0	10,419,900.0
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,999,900.0	2,499,900.0
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		7,920,000.0
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,257,815.97)	(10,419,900.0)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	470,000.0	3,169,039.0
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	470,000.0	

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	470,000.0	(3,169,039.0)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(8,332,320.4)	(40,815,276.44)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	97,447,532.1	89,115,211.7
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89,115,211.7	48,299,935.27

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэм жиг нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	1,215,417.6	1,337,534.0	1,200,320.3	137,213.70	89.74
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	мян.төг	1,098,846.5	1,121,034.0	978,103.5	142,930.50	87.25
	Орон нутгийн чанартай	мян.төг	116,571.1	216,500.0	222,216.8	(5,716.80)	102.64
2	Нийт зардал	мян.төг	1,180,206.0	1,284,399.6	1,198,021.6	86,378.00	93.27
	Үйл ажиллагааны зардалд	мян.төг	241,899.7	235,345.0	225,723.0	9,621.96	95.91
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	35,211.6	53,134.4	2,298.7	50,835.70	4.33
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	31,690.4	47,821.0	2,068.8	45,752.13	4.33
5	Төсвийн төлбөр	мян.төг	299,970.3	266,288.7	254,334.4	11,954.31	95.51
	а. Орлогын татварт	мян.төг	3,521.2	5,313.4	229.9	5,083.53	4.33
	б. НӨАТ	мян.төг	157,283.6	133,753.4	109,120.0	24,633.37	81.58
	в. НДШ	мян.төг	108,025.1	109,012.3	117,625.5	(8,613.19)	107.90
	г. ХХОАТатварт	мян.төг	23,732.5	13,422.1	21,787.2	(8,365.10)	162.32
	д. Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	2,366.2	1,680.3	2,247.9	(567.60)	133.78
	е. Газрын төлбөр	мян.төг	2,028.5	1,072	1,217.2	(145.60)	113.59
	ё. Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	2,095.2	1,117.6	1,188.7	(71.10)	106.36
	ж. Бусад татварт	мян.төг	918.0	918.0	918.0	-	100.00
6	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	3,169.0	4,782.1	34.5	4,747.62	0.72
7	Ажиллагсдын тоо	хүн	38.0	39.0	37.0	2.00	94.87
8	Цалингийн сан	мян.төг	413,195.8	419,278.1	384,042.8	35,235.31	91.60
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	906.13	895.89	865.0	30.93	96.55
10	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.97	0.96	0.99	(0.03)	103.10
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	7,999.9	25,420.0	10,420.0	15,000.00	40.99
12	Нийт авлага	мян.төг	186,978.4	176,780.5	177,837.2	(1,056.70)	100.60
13	Нийт өглөг	мян.төг	750,984.2	726,893.5	726,893.5	-	100.00
	Богино хугацаат өглөг	мян.төг	124,090.3	100,000.0	100,000.0	-	100.00
	Урт хугацаат өглөг	мян.төг	626,893.9	626,893.9	626,893.9	-	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 02-наас 2022 оны 03 дугаар сарын 11-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон АЗЗА ТӨХК -ийн 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Зам тээврийн яамнаас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Орхон АЗЗА ТӨХК 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 1,215,417.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,231.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг дахин үнэлж 2021 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг оруулахад нийт орлого 1,200,320.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар материаллаг байдлын түвшинг тооцоход сонгосон материаллаг байдал нь 18,004.8 мянган төгрөг болж төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын үзүүлэлтээс 226.5 мянган төгрөгийн зөрүү үүссэн тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны санхүүгийн тайлангийн дүнгүүдээр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Тиймээс гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг 2021 оны нийт орлогоос 1.5 хувиар тооцож 18,004.8 мянга, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдал нь 75%-иар тооцож 13,503.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Орхон АЗЗА ТӨХК нь компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах үүднээс өр авлага, үргүй зардлыг багасгах, хөрөнгө хүн хүч, техникийн боломждоо тулгуурлан ажлын байр шинээр бий болгох, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилтан, ажилчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, үр ашигтай тогтвортой үйл ажиллагааг явуулах зорилготой ажиллаж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг хатуу болон хайрган хучилттай авто зам барилгын ажил барих, засварлах, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Орхон АЗЗА ТӨХК нь Засгийн газрын 2006 оны 08 дугаар 10-ны өдрийн 173 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 6-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих”, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл “Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх”, 62.1.7-д “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалттай нийцэж байна.

Орхон АЗЗА ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалин 220.0 мянга, 9 гишүүдийн цалин 200.0 мянга жилдээ нийт 24,240.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд санхүүгийн Unicus программыг ашиглалтад оруулж, тус программд нэвтрэх 3 эрхтэй ажилтантай бөгөөд ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан, нярав нар өдөр тутмын ажил гүйлгээг оруулж байна.

Тус программд үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй оруулахдаа эд хариуцагч бүрийн нэрийг хөрөнгө бүрийн ард тусгаж өгсөн нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын хүрээнд жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа 2 ажилтны оронд шинээр ажилтан аваагүйгээс хамаарч цалингийн зардлыг 35,235.3 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлаас 15,000.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна. Оны эцэст ажилтнуудад 13 дах сарын цалинг ажлын гүйцэтгэлээс хамааран олгодог байсныг олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг тайлант онд гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Авто замын тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр тус тус өөрчлөлт орсон.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Орхон АЗЗА ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	89,115.2	48,299.9	(40,815.3)

БХХО			
Авлага	186,978.4	168,686.1	(18,292.3)
Урьдчилгаа			
Бараа материал	66,627.6	171,904.3	105,276.7
Үндсэн хөрөнгө	646,551.9	643,501.3	(3,050.6)
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн	989,273.2	1,037,430.7	48,157.5
Өр төлбөрийн дүн	750,994.7	171,464.7	(579,530.0)
Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	629,227.7	626,893.9	(2,333.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	989,273.2	1,037,430.7	48,157.5

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд тайлант онд нийт 31,800.0 мянган төгрөгийн орлого орж 31,656.3 мянган төгрөг зарцуулж оны эцэст 335.4 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа Богд банканд 160.6 мянган төгрөг, Голомт банкны 1,119.8 мянган төгрөг, Төрийн банкны 46,684.1 мянган төгрөг, нийт 47,964.5 мянган төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын 2,938.1 мянган төгрөг дампуурсан Капитал банканд байршуулсан байна.

Авлагын үлдэгдэлд Капитал банкнаас авах авлага 2,938.1 мянга, Төгс цас ХХК-аас авах авлага 3,630.0 мянга, “Харбин” ХХК-аас авах авлага 160,000.0 мянга, иргэн Цэвэлмаагаас авах авлага 2,118.0 мянга, нийт 168,686.1 мянган төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд авлага нэмэгдээгүй, дээр дурдсан авлагууд нь өмнөх онуудад үүссэн авлага байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 3,630.0 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 165,056.1 мянган төгрөгийн найдваргүй авлага байна. Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дугаар тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-т найдваргүй авлагыг шүүхийн шийдвэрээр авлагыг цуглуулах боломжгүй болсон нь тогтоогдсон үед болон удирдлагын бусад шийдвэрээр Дт:Найдваргүй авлагын хасагдуулга

Кт: Дансны авлага аргаар тооцдог байна.

Иргэн Э.Цэвэлмаагаас авах авлагыг Орхон АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 06 дугаар албан бичгээр анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Мөн Харбин ХХК-аас авах авлага 160,000.0 мянган төгрөгийг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 192500440 дугаартай мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд одоогоор эцэслэн шийдэгдээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 171,904.3 мянган төгрөг болж 105,276.7 мянган төгрөгөөр өссөн нь асфальт бетон хольц 62,815.9 мянга, ажилчдын нормын хувцас 4,578.2 мянга, бусад замын тэмдэг, тэмдэглэгээ, хайрга 25,298.6 мянга, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 2,272.6 мянган төгрөгийн нээтбүүк, 7,200.0 мянган төгрөгийн санхүүгийн Unicus программ, үнэ төлбөргүй хүлээн авсан 33,352.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгслээр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй. Оны эцэст 243,558.6 мянган төгрөгийн битум, хольц худалдан авалт хийсэн нь 2021 оны 08 дугаар сараас эхлэн 12 сар хүртэл санхүүжилт ороогүй, байгууллагад өгөх өр төлбөр үүссэнийг 12 дугаар сард санхүүжилт орсны дараа төлж барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй, шинээр 9,472.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 117 дугаар тогтоолоор 26,352.4 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий Ниссан патрол маркийн тээврийн хэрэгслийг “Үндэсний давхар даатгал” ХК-аас балансаас балансад, 2021 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 137 дугаар тогтоолоор Киа бонго маркийн тээврийн хэрэгслийг 1,500.0 мянган төгрөгийн өртгөөр балансаас балансад, 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 360 дугаар тогтоолоор Хьюндай Старикс 3,000.0 мянган төгрөг, Трубоукладчик 2,500.0 мянган төгрөгийн өртгөөр Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын балансаас Орхон АЗЗА ТӨХК-ийн балансад тус тус шилжүүлсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 457 дугаар тогтоолоор 70,006.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 457 дугаар тогтоолоор нийт 66,806.9 мянган төгрөгийн өртөгтэй, 66,806.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 16 ширхэг хөрөнгийг акталжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 171,475.2 мянган төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2006 онд Кувейтийн сан буюу Засгийн газрын гэрээтэй тээврийн хэрэгсэл, механизм хөрөнгө оруулалтаар ирж түүний дүнг бүртгэснээс үүссэн 626,893.9 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 17,815.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Ковид цар тахлаас хамаарч материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэлийн ажилчдын цалин, ашиглалтын зардал, авто тээврийн оношилгоо, татвар, шатахууны зардал, элэгдлийн зардал, хөдөлмөр хамгааллын, ахмадын зардлуудыг хамруулсан байна. Үүнээс ахмадын зардал өртөгт хуваарилагдахгүй зардал байна. Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дугаар тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-т тодорхой тусгаагүй байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Орхон АЗЗА ТӨХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 620 дугаар тогтоолоор Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,337,534.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,281,386.9 мянган төгрөгөөр, 50,532.4 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 25,420.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,200,320.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,198,021.6 мянган төгрөгийн зардал гарган, 2,298.7 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,200,320.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 137,213.7 мянган төгрөг буюу 10 хувиар бага харагдаж буй орлого үр дүнгийн тайланд нэмэгдсэн ертгийн албан татварыг хасаж тооцсоноос шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,198,021.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 83,365.3 мянган төгрөг буюу 6.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь хөрөнгө оруулалтын зардлаас 15,000.0 мянга, цалингийн сангаас 35,235.3 мянга, үйл ажиллагааны зардал 9,621.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 2 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 9,472.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажилд 18,025.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийж үндсэн хөрөнгийг капиталжуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,068.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 48,463.6 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө 100% биелүүлээгүй нь нөлөөлж байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 228 дугаар тогтоолын дагуу 2020 оны 3,169.04 мянган төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээс 3,169.04 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт 394,410.0 мянган төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийн хугацаа болоогүй, бусад 171 мэдээллээс 780.0 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 163 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", Хамтын гэрээ болон хөдөлмөрийн дотоод журмын 7.3-т "ажлын зайлшгүй шаардлагын улмаас байгууллагын хэвийн үйл ажиллагаанд учирсан саадыг арилгах хойшлуулах боломжгүй ажил гүйцэтгэх тохиолдолд гүйцэтгэх захирал, ерөнхий инженерийн шийдвэрээр илүү цагаар ажиллуулж болно" гэж заасан нь шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,482.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 10,770.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	3	13,482.0	3	13,482.0			
Зөвлөмж	3	10,770.0	3	10,770.0			
Нийт дүн	6	24,252.0	6	24,252.0			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор томилогдсон Орхон АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Булган АЗЗА ТӨХК, Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөр давхар ажиллаж буй нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.8-д “Энэ журамд заасны дагуу төрийн өмчийн төлөөллийн хэрэгжүүлэхээр томилогдсон төрийн захиргааны албан хаагч 2-оос илүү төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байх тул ҮАГ-т энэ талаар хяналт хэрэгжүүлэх саналыг хүргүүлж байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,002.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,587.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 29,415.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3 алдаа, зөрчлийн дүн 31,002.5 мянган төгрөг ба үүнээс 29,415.4 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг материаллаг бус гэж үзсэн, харин үлдсэн 2 алдаа зөрчлийн 1,587.1 мянган төгрөгийг материаллаг зөрчил гэж үзсэн.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 18,004.8 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчлийн дүн хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа: Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт

- Кассын нярав нь 2021 оны 02 сард бүтэн ажиллаад 3 дугаар сарын 01-ны өдрөөс ээлжийн амралтаа авч нийт 26 хоног амрахаас 3 дугаар сард ажлын 22 хоногтой, 4 сарын цалингаас 4 хоногийн цалин дутуу бодогдох ёстой байтал 3 сард 7 хоногийн цалин 318.1 мянган төгрөгийг илүү бодож олгосон.
- Тооцооны нягтлан бодогч нь 2021 оны 9 сард 22 хоног ажиллахаас 17 хоног ажиллаад ээлжийн амралтын 26 хоногийн олговор авсан. 2021 оны 06 дугаар сард ээлжийн амралтаас 5 хоног, 8 дугаар сард 5 хоног нийт 15 хоног эдэлж, үлдсэн 11 хоногийн ээлжийн амралтын олговор, цалин хөлс 513.8 мянган төгрөгийг давхардуулан авсан.

Орхон АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

- Ерөнхий инженер нь 2021 оны 11 дүгээр сард 22 хоног ажиллахаас 18 хоног ажиллаад 22 хоногийн ээлжийн амралтын олговроо цалинтай хамт авсан. 12 дугаар сард 8 хоногийн илүү цалин 755.1 мянган төгрөг бодогдсон.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон 1,587.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн программын тохиргоо бүрэн хийгдээгүйгээс сар бүрийн нийт олговол зохих цалингийн дүн Нийгмийн даатгалын тайлангийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгүүд хоорондоо зөрүү үүссэнийг тайлант оны сүүлийн 8-11 дүгээр саруудад тааруулж зассан нь иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программын тохиргоог тухай бүр хийлгэж, сар бүрийн нийгмийн даатгалын тайланг, цалингийн цэсний нийт дүнтэй тулган баталгаажуулж байх.

2. Урсгал зардалтай холбоотой асуудалИлрүүлэлт:

Ажилтнуудад тайлант оны 5-10 дугаар саруудад нийт 29,415.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгохдоо эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын иж бүрэн байдал дутуу, хүний нөөцийн ажилтны цагийн тооцооны хуудсыг үндэслэн олгосон нь Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээ болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "ажлын зайлшгүй шаардлагын улмаас байгууллагын хэвийн үйл ажиллагаанд учирсан саадыг арилгах хойшлуулж боломгүй ажил гүйцэтгэх тохиолдолд гүйцэтгэх захирал, ерөнхий инженерийн шийдвэрээр илүү цагаар ажиллуулж болно" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зайлшгүй ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах тохиолдолд Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээ болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу захирлын гаргасан шийдвэрийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг үнэлж илүү цагийн хөлс олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Орхон АЗЗА ТӨХК	ОРА-2022/1/НА/СТА-ТӨХК	Нярав, тооцооны нягтлан бодогч, ерөнхий инженер нарт ээлжийн амралтын олговор, цалин хөлс давхардуулан олгосон.	Төлбөрийн акт тогтоосон.						1	1,587.1					
2			Санхүүгийн программын тохиргоо бүрэн хийгдээгүйгээс сар бүрийн нийт олговол зохих цалингийн дүн Нийгмийн даатгалын тайлангийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгүүд хоорондоо зөрүү үүссэн	Санхүүгийн программын тохиргоог тухай бүр хийлгэж, сар бүрийн нийгмийн даатгалын тайланг, цалингийн цэсний нийт дүнтэй тулган баталгаажуулж байх.											1	
3			Ажилтнуудад тайлант оны 5-10 дугаар саруудад нийт 29,415.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгохдоо эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын иж бүрэн байдал дутуу, хүний нөөцийн ажилтны цагийн тооцооны хуудсыг үндэслэн олгосон	Зайлшгүй ажлын шаардлагаар илүү цагаар ажиллах тохиолдолд Үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээ болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу захирлын гаргасан шийдвэрийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг үнэлж илүү цагийн хөлс олгож байх.												1
ДҮН					3	31,002.5				1	1,587.1				2	29,415.4